



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 1/2025

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газраас холбогдох байгууллагуудтай хамтран сумдад “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болон “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийн нээлт хийж, байгууллага бүр үндсэн чиг үүргийн дагуу иргэдэд мэдээлэл өгч, иргэдийн санал гомдол, эрэлт хүсэлтийг хүлээн авч, зарим төрийн үйлчилгээг газар дээр нь шуурхай хүргэх үйл ажиллагааны зардалд 13 679 100 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 13 679 100 төгрөг /Арван гурван сая зургаан зуун далан есөн мянга нэг зуун/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн 5.29-д тусгагдсан “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 01097
D/Zax-A/225-Da

Аймгийн Засаг даргын 2019 оны
04 дүгээр сарын 09-ний өдрийн
А/225 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ХОЛБОГДОХ
БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН СУМДАД "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР"
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДАЛ

№	Арга хэмжээний нэр	Зардлын дүн /төгрөг/
1.	Албан томилолтын зардал	3.975.000
2.	Шатахууны зардал	3.094.100
3.	Зохион байгуулалтын зардал	6.610.000
	Дүн	13.679.100

-oOo-